

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны ... сарын ... өдөр

Дугаар ... / ...

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүх шинжилгээний тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга (цагдаагийн хурандаа Ж.Буянбат), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (П.Сайнзориг), Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Цогтгэрэл) нарт тус тус даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Х.НЯМБААТАР

Б.БАТ-ЭРДЭНЭ

Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2023 оны дугаар сарын-ны өдрийн
...../..... дугаар хамтарсан тушаалын хавсралт

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ХОХИРЛЫН ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартыг дагаж мөрдөнө.

1.3.Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийхдээ Шүүх шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

Хоёр. Шинжилгээний төрөл

2.1. Дараах шинжилгээний төрөлтэй байна.

- 2.1.1 Амьтны шинжилгээ;
- 2.1.2 Ургамлын шинжилгээ;
- 2.1.3 Агаарын шинжилгээ;
- 2.1.4 Усны шинжилгээ;
- 2.1.5 Хөрсний шинжилгээ;
- 2.1.6 Ой, модны шинжилгээ;
- 2.1.7 Химийн бодисын шинжилгээ;
- 2.1.8 Ашигт малтмалийн агууламж тодорхойлох шинжилгээ;
- 2.1.9 Бусад.

Гурав. Шинжилгээний лабораторид тавигдах шаардлага

3.1.Шинжилгээг тусгай тоногосон лабораторийн өрөө, тасалгаанд хийнэ.

3.2.Лабораторийн тоног төхөөрөмжийг газардуулга болон зориулалтын төхөөрөмжтэй холбож, цахилгаан тасалдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна.

3.3.Шинжээчдийн аюулгүй байдлыг хангасан зориулалтын төхөөрөмж, нүд угаагуур, аюулгүйн шүршүүр зэрэг хэрэгслээр лабораторийг тоногосон байна.

3.4.Лаборатори нь байгалийн гэрэлтүүлэгтэй, дулаан, цэвэр бохир усны сүлжээнд холбогдсон байна.

3.5.Лабораторийн ширээ нь ариутгаж халдваргүйжүүлэхэд тохиромжтой, хүчил шүлтэнд тэсвэртэй гадаргуутай байна.

3.6.Бодис урвалж, уусмалуудыг хадгалах шүүгээ нь ямар төрлийн бодис хадгалж байгаа талаарх мэдээлэл бүхий хаягтай байна. Хамт хадгалж болохгүй химийн бодисуудыг тус тусад нь хадгална.

3.7.Шаардлагатай бэлэн байдлыг хангаж, яаралтай горимд ажиллах үед урвалжийн нөөцийг бүрдүүлнэ. Лабораторийн нөөц, урвалж бодисын жагсаалтыг баталсан байна.

Дөрөв. Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээний объектод тавих шаардлага

4.1.Холбогдох заавар, журмын дагуу сорьц, дээжийг авч, зориулалтын саванд хаяглан битүүмжилсэн байна.

4.2.Шинжилгээний сорьц, дээж, загвар нь тухайн объектыг бүрэн төлөөлж чадахуйц, чанар, тоо хэмжээний хувьд шаардлага хангасан байна.

4.3.Шинжилгээний объект, баримт материалыг эх хувиар нь ирүүлэх боломжгүй тохиолдолд шинжээч нь эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр газар дээр нь очиж объектод үзлэг шинжилгээ хийнэ.

4.4.Шаардлагатай тохиолдолд шинжээч нь шинжилгээний объект, дээжийг биечлэн авч болно.

Тав. Шинжилгээний объектыг хадгалах, тээвэрлэх ерөнхий шаардлага

5.1.Шинж чанараа амархан алдаж болзошгүй шинжилгээний объектын хадгалах нөхцөлийг шинжилгээ хийх үйл ажиллагаатай уялдуулан тооцоолох ба шаардлагатай тохиолдолд шинжилгээг яаралтай хийж, бодит байдлыг баталгаажуулна.

5.2.Шинжээч нь шинжилгээний объектын онцлогоос хамаарч түүний хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг биечлэн хариуцах бөгөөд орчиндоо аюултай шинжилгээний объектыг тусгай өрөө, тасалгаа эсвэл хөргөх систем бүхий зориулалтын саванд тус тус хадгална.

5.3.Хэргийн газраас авсан болон шинжилгээнд ирүүлсэн хөрсний дээжийг зориулалтын саванд хийж, хөрсний чийг, температурыг алдагдуулахааргүй нөхцөлд хадгалж 48 цагийн дотор лабораторид хүргэж шинжилгээ хийлгэнэ. Хэрэв дээрх хугацаанд лабораторид хүргэх, шинжлэх боломжгүй бол 4-5°C хөргөгчид хийж, хадгална.

5.4.Хэргийн газраас авсан болон шинжилгээнд ирүүлсэн усны дээжийг тухайн нөхцөл байдлын чанар алдагдахааргүй битүүмжлэн 48 цаг хүртэлх хугацаанд 0°C-4°C температурт хөргөж, нарны шууд тусгалаас хол хадгална. Шинж чанараа амархан алдаж болзошгүй дээжийг яаралтай шинжилгээнд хамруулах эсхүл гүн хөлдөөх (-18°C-аас доош) замаар удаан хугацаанд тогтвортой байлгаж болно.

5.5.Хэргийн газраас авсан болон шинжилгээнд ирүүлсэн том хөхтөн, шувуу тэдгээрийн эд эрхтэн арьс, шир, хошуу, сарвуу, туурай, үс ноос, яс хэсгийг дээжийн онцлогоос шалтгаалан тасалгааны температурт зориулалтын шүүгээ эсвэл уутанд, түргэн муудах объект, дээжийг хөлдөөгчид -20°C-т хадгална. Жижиг хөхтөн, жижиг загас, хоёр нутагтан, мөлхөгчид, шавжийг 50-75% -ийн спирт болон зориулалтын уусмалтай шил болон хуванцар саванд (хэрэв дотор нь шошго хийх бол балын харандаа хэрэглэнэ), битүүмжлэл сайтай модон хайрцаг, зориулалтын шүүгээнд хийж шошго хийн хадгална.

5.6.Хэргийн газраас авсан болон шинжилгээнд ирүүлсэн ургамлыг байгалийн өнгө, хэлбэрийг алдагдуулахгүйгээр аль болох богино хугацаанд гербарын хавтсанд хийж хатаах хэрэгтэй. Хатаах ургамлыг 35⁰C- ээс 40⁰C-ийн температурт хатааж 10-12⁰C хэмийн температуртай, агаарын чийг 60%-аас багагүй, эрүүл ахуйн шаардлага хангасан шороо тоосгүй, хуурай агаар сэлгэлттэй буюу зориулалтын салхивчтай газарт хадгална. Дулааны горим алдагдвал хортон үржих, түүхий эд үйрэх, биологийн идэвхт бодисын хэмжээ багасах эрсдэлтэй.

5.7.Модны дээжийг бэлтгэн авахдаа 5-10 см зузаантай хөндлөн зүсэлт хийж авна. Дээжийг хайрцаг, саванд хийн жилийн цагаригийг гэмтээхгүйгээр битүүмжилж шинжилгээнд ирүүлнэ.

5.8.Шинжилгээнд ирүүлж байгаа дээжийг шороо, тоосоор бохирдохоос хамгаалж битүүмжлэл сайтай зориулалтын саванд хийж тээвэрлэнэ.

5.9.Шинжилгээнд ирүүлж байгаа дээжийг бензин, керосин болон химийн хорт шинж чанарыг нь алдагдуулах аливаа бодис хурц үнэртэй гэр ахуйн болон гоо сайхны бүтээгдэхүүнүүдтэй хамт тээвэрлэж, хадгалахыг хориглоно.

Зургаа. Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

6.1.Шинжээч шинжилгээ хийлгэх шийдвэртэй танилцан шинжилгээний объектыг биечлэн хүлээн авч, цаашид шинжилгээ хийх боломжтой эсэх талаар шийдвэр гаргана.

6.2.Шинжээч нь хүлээн авсан шинжилгээний объектыг гэрэл зураг болон бусад арга хэрэгслээр бэхжүүлэн авсны дараа батлагдсан аргачлалын дагуу шинжилгээ хийнэ.

6.3.Шинжилгээнд ирүүлсэн объектыг шинжилгээний арга, аргачлалын дагуу гэмтээж, шинж чанарыг нь өөрчлөхөөр байвал шинжээч шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд энэ талаар урьдчилан мэдэгдэнэ.

6.4.Шинжээч нь шинжилгээ хийх боломжгүй гэж үзвэл шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд нэн даруй албан бичгээр хариу мэдэгдэнэ.

6.5.Шинжээчийн дүгнэлтийг хэвлэмэл маягтан дээр үйлдэх ба өөрөөр үйлдэхийг хориглоно.

6.6.Шинжээч нь шинжилгээний объект, бусад шаардлагатай баримт материалын эх хувийг газар дээр нь очиж шинжилгээ хийх шаардлагатай гэж үзвэл энэ тухайгаа удирдах албан тушаалтанд танилцуулж, шаардлагатай багаж төхөөрөмж, албаны унааг ашиглана.

6.7.Шинжээч нь шинжилгээнд шаардлагатай материал буюу загвар авч шинжилгээнд ашиглаж болно.

6.8.Шинжээч нь өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд бусад алба хаагч нарт зөвлөх, аюулгүй байдлын зааварчилгаа өгч болно.

6.9.Шинжилгээний байгууллага шаардлагатай тохиолдолд хүрээлэн байгаа орчны шинжилгээний объектыг мэргэжлийн байгууллагын лабораторид илгээж, гарсан үр дүнг үндэслэн дүгнэлт гаргаж болно.

6.10.Шинжээчдийн баг нь хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг хийхдээ шаардлагатай тохиолдолд үнэлгээ хийгдсэн талбайд очиж дээж авч ажиллана.

6.11.Шинжээчдийн баг нь хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох” аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ.

Долоо. Лабораторийн аюулгүй ажиллагаа

7.1.Шинжилгээний лабораторид ажиллах албан хаагч нь аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцсан байна.

7.2.Шинжилгээний сорилт, туршилтын ажил дууссаны дараа ашигласан багаж, тоног төхөөрөмжүүдийг унтрааж, цахилгааны эх үүсвэрээс салгана.

7.3.Биологийн дээжтэй харьцах үед халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиж, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл өмсөнө. Ашигласан нэг удаагийн хамгаалах хэрэгслийг уутанд хийж, устгалд оруулна.

7.4.Лабораторийн багаж, тоног төхөөрөмжийг ажиллуулахын өмнө техникийн бүрэн бүтэн байдлыг шалгана.

7.5.Лабораториос гарч явахдаа ашигласан бүх багаж тоног төхөөрөмжөө салгасан эсэх, усны хаалт, гэрлээ унтраасан эсэхийг тогтмол шалгана.

7.6.Цахилгаанаар ажилладаг багажийг тухайн багажны тасралтгүй ажиллах дээд хугацаанаас хэтрүүлэхгүйгээр ашиглана.

7.7.Лабораторийн ширээн дээр шатамхай шингэн асгавал тэр дор нь халаагуур болон цахилгаанаар ажилладаг багажуудыг салгах ба асгарсан шингэн дээр элс асгаж, модон хутгуураар хаман авч, уг газрыг сайн угааж, цэвэрлэнэ.

7.8.Лабораторид хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл, эмийн сан, аюулгүй ажиллагааны иж бүрдэл зэргийг бэлэн байлгана.

7.9.Шинжилгээний зориулалтаар хэрэглэх химийн бодисуудыг тухайн лабораторийн өрөөнд тусгай зориулалтын шүүгээнд хадгална.

Найм. Хориглох зүйл

8.1.Дараах үйл ажиллагааг хийхийг хориглоно.

8.1.1.тусгай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, байрлалаас нь хөдөлгөх, шилжүүлэх, тохиргоог өөрчлөх;

8.1.2.лабораторийн үйл ажиллагаа, шинжилгээний явц, үр дүн, техник, хэрэгсэл, баримт бичиг, сан, цуглуулгын талаар нарийвчилсан мэдээлэл олж авч хувийн зорилгоор ашиглах;

8.1.3.лабораторид шинжилгээний объектоос бусад эд зүйл хадгалах;

8.1.4.ажлын болон хувийн хувцас, хэрэглэлийг хамт хадгалах;

8.1.5.лабораторид бүрэн ажиллагаатай цахилгаан хэрэгслийг ашиглах ба тусгаарлагч нь гэмтсэн цахилгаан гүйдэлтэй утас, залгуур нь эвдрэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглах;

8.1.6.багаж, тоног төхөөрөмжийг ашиглах үедээ хараа хяналтгүй орхих;

8.1.7.лабораторийн багаж, тоног төхөөрөмж эвдэрсэн тохиолдолд зөвшөөрөлгүй засварлах;

8.1.8.шатамхай бодисыг спиртэн дэн болон цахилгаанаар ажилладаг багаж хэрэгсэл, татах шүүгээ, исэлдүүлэгчид (хлор, нитрат, марганц гэх мэт) ойр хадгалах;

8.1.9.шатамхай бодистой ажиллаж байх үед татах шүүгээг ажиллуулах.